

2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН 31-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-03-31

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 04 дүгээр сарын 07-ны “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, удаашралтай байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх.	Худалдан авах ажиллагааны алба
2.	Хүүхэд, залуучуудын хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг сайтар хангаж, цахилгаан дугуй, скүүтэрийн хэрэглээнд хяналт тавьж ажиллах.	Цагдаагийн хэлтэс
3.	Тээврийн хэрэгслийн албан татвар, торгуулиа төлөөгүй тохиолдолд камерыг ашиглан илрүүлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллах.	Цагдаагийн хэлтэс
4.	Нийслэлийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд орчин тойрныхоо хог хаягдлыг цэвэрлэх, хайс, хашлага, фасадыг угаах, тохижуулах ажлыг зохион байгуулах тухай албан даалгавар гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ
5.	Нөөцийн махны нийлүүлэлтэд анхаарч ажиллах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
6.	Сүү хөтөлбөрийн ажлаа эрчимжүүлэх.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Боловсролын байгууллагууд
7.	Барилга, байгууламжийн ажил эхэлж элс, хайрга, дайрга тээвэрлэж байгаа том оврын автомашинуудын техникийн үзлэг, аюулгүй байдалд хяналт тавих.	Цагдаагийн хэлтэс
8.	Орон сууцны хороолол дундах болон гэр хорооллын гудамж, явган хүний зам,	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай

	автозамын эвдрэл гэмтлийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулах.	Тохижилт ОНӨААТҮГ
9.	Барилга байгууламж, объектуудыг нийслэлийн өмчид бүртгүүлэх ажлуудаа эрчимжүүлэх.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Холбогдох байгууллагууд
10.	Хүүхдийн хоол, хүнсний үйлдвэрлэлтэй холбоотой тулгамдаж байгаа асуудлын талаар танилцуулах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Боловсролын байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
11.	Үе тэнгийн дээрэлхэлтийн талаарх судалгааг олон нийтэд танилцуулах	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс
12.	Мал бүхий иргэдийн татвар төлөлтөд хяналт тавих, татвар төлөлтийн талаар танилцуулах	Засаг даргын орлогч, Татварын хэлтэс, статистик, Хороод
13.	Дүүргийн төсвийн тодотголд бэлтгэх	Санхүү төрийн сангийн хэлтэс
14.	Хороо хоорондын зам болон нийтийн эзэмшлийн талбайн орчны цэвэрлэгээг хийх	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ
15.	Нохой, муур устгах ажлыг зохион байгуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ
16.	Ногоон байгууламжийн чиглэлээр зохион байгуулагдах сургалтад хамрагдах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ
17.	Хөрөнгө оруулалтаар хийгдэх барилгын ажлуудыг эхлүүлэх, хяналт тавих ажлын хэсгийг шинэчлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Холбогдох байгууллагууд
18.	Мал хориглох бүсийн ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх, хариуллагагүй малд хяналт тавих	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
19.	УБТЗ-ын 10 дугаар замтай холбоотой ажлын хэсэгтэй уулзалт зохион байгуулах	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
20.	Том оврын ачааны автомашины авто замын хөдөлгөөнийг зохицуулах, хяналтыг сайжруулах	Цагдаагийн хэлтэс

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ